



“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ

АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын
нэр:

36 АЙЛЫН ОРОН СУУЦ

Тендер шалгаруулалтын
дугаар:

МРЦМ/20240101087

Улаанбаатар хот

2024 он

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА	6
II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ	18
III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	24
IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	28
V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ	29
VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ	33

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6. Сонирхогч этгээд, оролцогчид

6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер

тавигдах өрөнхий шаардлага

шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу өрөнхий шаардлагыг хангасан байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол өрөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3. Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2. Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3. Тодруулга авах хүсэлтийд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл

тендерийн хэл

хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1. ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3. ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;

13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд

14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15. Хувилбарт санал

15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

**16. Ерөнхий шаардлагыг
магадлах баримт бичиг**

16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1. ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

- 17. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.
- 17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.
- 17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.
- 17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.
- 18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.
- 18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.
- 19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

- 19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**
- 20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.
- 20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.
- 20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.
- 21.3. Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.4. ТШЗ-ны 21.2-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.
- 21.5. ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.
- 21.6. Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.7. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.

- 22. Тендерийн валют**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.
- 23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.
- 23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцгчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа**
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцгчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.
- 25.3. Оролцгчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.** 7-ын дагуу н ууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхул түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.

30. Арифметик алдааг залруулах

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

31. Давуу эрх олгох

31.1. Захиалагч нь хуулийн 8.4, 8.7-д зааснаар давуу эрх олгоход оролцогчийн ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу үнийг хийсвэрээр бууруулж тооцно.

31.2. ТШЗ-ны 31.1-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.

32. Үнэлгээнд харгалзах

32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан

шалгуур үзүүлэлт

Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох

- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:
- 33.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;
 - 33.1.2. ТШЗ-ны 21.5-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;
 - 33.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
 - 33.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;
 - 33.1.5. ТШЗ-ны 31.1-д зааснаар давуу эрх олгох;
 - 33.1.6. ТШЗ-ны 32.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
- 33.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:
- 33.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;
 - 33.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 35-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;
 - 33.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.

- 33.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.
- 33.4. ТШЗ-ны 33.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34. Тендерийг эрэмбэлэх**
- 35. Оролцогчийн чадавхыг дахин магадлах**
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 36. Мэдэгдэл хүргүүлэх**
- 37. Гүйцэтгэлийн баталгаа**
- 38. Урьдчилгаа төлбөр**
- 36.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38.1. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 38.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт

ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.

- 38.3. Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.

39. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах

- 39.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 39.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 39.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.
- 39.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: “Монголросцветмет” төрийн өмчийн үйлдвэрийн газар
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: 36 айлын орон сууц
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: МРЦМ/20240101087
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: “Үгүй”
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Захиалагч өөрийн хөрөнгөөр
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 2, 800,000,000.00 төгрөг
Б.АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: Худалдан авалт, борлуулалтын хэлтэс Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-98, “Монголросцветмет” ТӨҮГ Утасны дугаар: 11-450060 Цахим шуудангийн хаяг: mailbox@monros.mn Тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлт гаргахдаа “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.3.4-т заасны дагуу www.tender.gov.mn -д тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар гаргах бөгөөд утсаар тодруулга, мэдээлэл өгөх боломжгүй болно.
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй” .
ТШЗ 16.1.2	Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана” <i>Тендерт оролцогч дараах нөхцлийдийн аль нэг нь үүсээгүй тухай мэдэгдлийг бичгээр гаргана. Үүнд:</i> 1. Төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах шийдвэр гарсан, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлсэн, бизнесийн үйл ажиллагааг зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эдгээртэй адилтгах нөхцөлд байгаа;

	<p>2. Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй;</p> <p>3. Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай этгээдийн оролцсон тендер шалгаруулалт, түүний багцад тендер ирүүлсэн;</p> <p>4. Тухайн тендер шалгаруулалтад оролцохдоо бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулсан, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцсон;</p> <p>5. Захиалагчаас хараат этгээд эсэх;</p> <p>6. Тендерт оролцогч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд, оролцогч компанийн эрх бүхий албан тушаалтны аль нэг нь авлигын, эсхүл мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;</p> <p>7. Тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахад зөвлөгөө өгсөн, оролцсон, эсхүл тухайн зөвлөгөө өгсөн, оролцсон этгээдтэй харилцан хамааралтай;</p> <p>8. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй;</p> <p>9. Тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан, эсхүл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд.</p>
ТШЗ 18.1	<p>Санхүүгийн чадавхын шаардлага: “<i>Шаардана</i>”. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - <i>Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022, 2023 онуудад гүйцэтгэсэн нийт борлуулалтын орлогын хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй байх.</i> - <i>Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ төсөвт өртгийн 50 хувиас багагүй байх.</i> - <i>Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өргүй байх</i> - <i>Сүүлийн гурав жил 2021,2022,2023 оны хугацаанд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу гаргасан санхүүгийн тайлан /Цахим/;</i> - <i>Сүүлийн гурав жил 2021,2022,2023 оны хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл.</i>
ТШЗ 18.2	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <p><i>Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацаа: 2021, 2022, 2023 оны жилийн тайлан.</i></p> <ul style="list-style-type: none"> - <i>харилцагч банкны мэдэгдэл;</i> - <i>Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойшихи өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдийн лавлагaa;</i> - <i>сүүлийн гурван жил 2021,2022,2023 оны хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл.</i> <p><i>“Цахим системээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах, түүний тасралтгүй аюулгүй ажиллагааг хангах журам” -ын 2.5 дахь заалтын</i></p>

	дагуу үнэлгээнд санхүүгийн тайлан болон татварын тодорхойлолт цахим системээс авагдах мэдээллийг ашиглана.																																																																												
ТШЗ 19.1	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана”</p> <p>Ажил гүйцэтгэх хүний нөөц: “Шаардана”</p> <table border="1"> <thead> <tr> <th>Албан тушаал</th><th>Хүний тоо</th><th>Ажилласан жил</th><th>Мэргэжил</th></tr> </thead> <tbody> <tr> <td>Ерөнхий инженер</td><td>1</td><td>5 жил /доошгүй/</td><td>Иргэний, үйлдвэрлэлийн барилгын инженер/ мэргэшсэн</td></tr> <tr> <td>Барилгын инженер, Талбайн даамал</td><td>1</td><td>3 жил /доошгүй/</td><td>Барилгын инженер</td></tr> <tr> <td>Халаалт салхивчийн инженер</td><td>1</td><td>3 жил /доошгүй/</td><td>Сантехникийн эсвэл дулаань инженер</td></tr> <tr> <td>Цахилгааны инженер</td><td>1</td><td>3 жил /доошгүй/</td><td>Цахилгааны инженер</td></tr> <tr> <td>Холбоо дохиоллын инженер</td><td>1</td><td>2 жил /доошгүй/</td><td>Холбоо, дохиолол, мэдээллийн инженер</td></tr> <tr> <td>Хөдөлмөр хамгааллын инженер</td><td>1</td><td>2 жил /доошгүй/</td><td>мэргэжлийн сертификаттай байх</td></tr> <tr> <td>Бетон арматурчин/угсралтын ажилтан</td><td>4</td><td>2 жил /доошгүй/</td><td>Мэргэжлийн үнэмлэхтэй байх</td></tr> <tr> <td>Гагнуурчин</td><td>2</td><td>2 жил /доошгүй/</td><td>Мэргэжлийн үнэмлэхтэй байх</td></tr> <tr> <td>Цахилгаанчин</td><td>2</td><td>2 жил /доошгүй/</td><td>Мэргэжлийн үнэмлэхтэй байх</td></tr> <tr> <td>Сантехникч</td><td>2</td><td>2 жил /доошгүй/</td><td>Мэргэжлийн үнэмлэхтэй байх</td></tr> <tr> <td>Краны машинист</td><td>1</td><td>3 жилээс /доошгүй/</td><td>Мэргэжлийн үнэмлэхтэй байх</td></tr> <tr> <td>Дотоод заслын ажил гүйцэтгэх бригад</td><td>8</td><td>3 жилээс /доошгүй/</td><td>Мэргэжлийн үнэмлэхтэй байх</td></tr> </tbody> </table> <ul style="list-style-type: none"> ✓ Төслийг удирдах ажилтан, инженерүүдийн 70-аас доошгүй хувь, нийт ажилллагдын 50-аас доошгүй хувь нь тухайн аж ахуйн нэгжид ажилладаг үндсэн ажилтан байна. /Үндсэн ажилтны товч анкет /ажлын туршлагын тухай агуулсан/, иргэний үнэмлэхний хуулбар ирүүлнэ. ✓ Нийгмийн даатгалын хэлтсээс олгодог баталгаажуулсан НД-8 маягтыг сүүлийн 3 сар /2024 оны 1-р сараас хойшиг/-ын байдлаар хавсарган ирүүлнэ./ Маягтаас тухайн байгууллагын үндсэн ажилтан мөн эсэхийг хянан үзнэ./ ✓ Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны инженерийн мэргэжлийн сертификатын хуулбарыг ирүүлнэ. ✓ Дээрх бүх инженерүүдийн боловсролын дипломын хуулбарыг ирүүлэх ✓ Мэргэжилтэй ажилтны мэргэжлийн үнэмлэхний хуулбарыг ирүүлнэ. <p>Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: “Шаардана”</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Машин механизмын тоног төхөөрөмжийн нэр</th><th>Х/Н</th><th>Тоо /шаардлагатай доод хэмжээ/</th></tr> </thead> <tbody> <tr> <td>1</td><td>Байшин кран /5 тн-оос доошгүй/ эсхүл автокран /10 тн-оос доошгүй/</td><td>Ш</td><td>1</td></tr> <tr> <td>2</td><td>Бульдозер/авто ачигч</td><td>Ш</td><td>1</td></tr> <tr> <td>3</td><td>Эксекватор /шанага 1.5м3-ээс багагүй/</td><td>Ш</td><td>1</td></tr> <tr> <td>4</td><td>Ачааны машин /10тн-оос багагүй/</td><td>Ш</td><td>1</td></tr> <tr> <td>5</td><td>Үйлчилгээний автомашин /2тн-оос багагүй/</td><td>Ш</td><td>1</td></tr> </tbody> </table>	Албан тушаал	Хүний тоо	Ажилласан жил	Мэргэжил	Ерөнхий инженер	1	5 жил /доошгүй/	Иргэний, үйлдвэрлэлийн барилгын инженер/ мэргэшсэн	Барилгын инженер, Талбайн даамал	1	3 жил /доошгүй/	Барилгын инженер	Халаалт салхивчийн инженер	1	3 жил /доошгүй/	Сантехникийн эсвэл дулаань инженер	Цахилгааны инженер	1	3 жил /доошгүй/	Цахилгааны инженер	Холбоо дохиоллын инженер	1	2 жил /доошгүй/	Холбоо, дохиолол, мэдээллийн инженер	Хөдөлмөр хамгааллын инженер	1	2 жил /доошгүй/	мэргэжлийн сертификаттай байх	Бетон арматурчин/угсралтын ажилтан	4	2 жил /доошгүй/	Мэргэжлийн үнэмлэхтэй байх	Гагнуурчин	2	2 жил /доошгүй/	Мэргэжлийн үнэмлэхтэй байх	Цахилгаанчин	2	2 жил /доошгүй/	Мэргэжлийн үнэмлэхтэй байх	Сантехникч	2	2 жил /доошгүй/	Мэргэжлийн үнэмлэхтэй байх	Краны машинист	1	3 жилээс /доошгүй/	Мэргэжлийн үнэмлэхтэй байх	Дотоод заслын ажил гүйцэтгэх бригад	8	3 жилээс /доошгүй/	Мэргэжлийн үнэмлэхтэй байх	№	Машин механизмын тоног төхөөрөмжийн нэр	Х/Н	Тоо /шаардлагатай доод хэмжээ/	1	Байшин кран /5 тн-оос доошгүй/ эсхүл автокран /10 тн-оос доошгүй/	Ш	1	2	Бульдозер/авто ачигч	Ш	1	3	Эксекватор /шанага 1.5м3-ээс багагүй/	Ш	1	4	Ачааны машин /10тн-оос багагүй/	Ш	1	5	Үйлчилгээний автомашин /2тн-оос багагүй/	Ш	1
Албан тушаал	Хүний тоо	Ажилласан жил	Мэргэжил																																																																										
Ерөнхий инженер	1	5 жил /доошгүй/	Иргэний, үйлдвэрлэлийн барилгын инженер/ мэргэшсэн																																																																										
Барилгын инженер, Талбайн даамал	1	3 жил /доошгүй/	Барилгын инженер																																																																										
Халаалт салхивчийн инженер	1	3 жил /доошгүй/	Сантехникийн эсвэл дулаань инженер																																																																										
Цахилгааны инженер	1	3 жил /доошгүй/	Цахилгааны инженер																																																																										
Холбоо дохиоллын инженер	1	2 жил /доошгүй/	Холбоо, дохиолол, мэдээллийн инженер																																																																										
Хөдөлмөр хамгааллын инженер	1	2 жил /доошгүй/	мэргэжлийн сертификаттай байх																																																																										
Бетон арматурчин/угсралтын ажилтан	4	2 жил /доошгүй/	Мэргэжлийн үнэмлэхтэй байх																																																																										
Гагнуурчин	2	2 жил /доошгүй/	Мэргэжлийн үнэмлэхтэй байх																																																																										
Цахилгаанчин	2	2 жил /доошгүй/	Мэргэжлийн үнэмлэхтэй байх																																																																										
Сантехникч	2	2 жил /доошгүй/	Мэргэжлийн үнэмлэхтэй байх																																																																										
Краны машинист	1	3 жилээс /доошгүй/	Мэргэжлийн үнэмлэхтэй байх																																																																										
Дотоод заслын ажил гүйцэтгэх бригад	8	3 жилээс /доошгүй/	Мэргэжлийн үнэмлэхтэй байх																																																																										
№	Машин механизмын тоног төхөөрөмжийн нэр	Х/Н	Тоо /шаардлагатай доод хэмжээ/																																																																										
1	Байшин кран /5 тн-оос доошгүй/ эсхүл автокран /10 тн-оос доошгүй/	Ш	1																																																																										
2	Бульдозер/авто ачигч	Ш	1																																																																										
3	Эксекватор /шанага 1.5м3-ээс багагүй/	Ш	1																																																																										
4	Ачааны машин /10тн-оос багагүй/	Ш	1																																																																										
5	Үйлчилгээний автомашин /2тн-оос багагүй/	Ш	1																																																																										

		6	Гагнуурын төхөөрөмж	ком	2
		7	Шаардлагатай бусад машин техник, тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны багаж хэрэгсэл	ш	Ажлын зурагт заагдсан ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах
Дээр дурдсан машин механизм нь тендерт оролцогчийн өөрийн өмчлөлийн эсвэл түрээсийн байж болно. Түрээсийн машин тоног төхөөрөмж ашиглах тохиолдолд түрээслүүлэгчтэй машин тоног төхөөрөмж ашиглах түрээсийн гэрээг Иргэний хуулийн холбогдох зүйлд нийцүүлэн хийсэн байх бөгөөд дуусах хугацаа нь ажил гүйцэтгэж дуусах хугацаа хүртэл хүчинтэй байна.					
Машин тоног төхөөрөмж нь тендерт оролцогчийн эсхүл түрээсийн болохыг дараах бичиг баримтаар нотлоно. Үүнд:					
<ol style="list-style-type: none"> 1. Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж бүрийн техникийн болон тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар 2. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хийсэн түрээсийн гэрээ <p>Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: “Шаардана”.</p> <p><i>Батлагдсан төсөөвт өртгийн үнийн дунгийн 50 хувиас багагүй үнийн дунтэй ижил төстэй ажлыг 2021, 2022, 2023 онуудын хугацаанд доод тал нь 1-ээс доошигүй удаа байх.</i></p> <p><i>Ижил төстэй ажил гэж “Цутгамал болон угсаргалт төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсаралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохижилтын ажил”-тай дүйцэх ажлыг ойлгоно.</i></p> <p>Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: “Шаардана”</p> <p>Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “Шаардана”</p> <ol style="list-style-type: none"> 1. Барилга угсаралт, өргөтгөл, шинэчлэлийн чиглэлийн ажил гүйцэтгэсэн туршлага: З жилээс багагүй байх 2. Ажил гүйцэтгэхэд ашиглах шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй байх: <i>ӨХ-ийн ТШЗ 19.1-т заасан жагсаалтын дагуу</i> 3. Түшилэл болон туслан гүйцэтгэгчийг зөвшөөрөх ба ТШЗ 7-д заасан “Туслан гүйцэтгэгч, түшилэл тавигдах шаардлага” болон ТШЗ-ын 19.4-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангасан байна. 					
ТШЗ 19.2	Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:				
	<ul style="list-style-type: none"> - 2021, 2022, 2023 онд ижил төстэй заагдсан ажил гүйцэтгэсэн гэрээний талаар V бүлгийн маягт 4,6-ын дагуу бэлтгэсэн мэдээлэл; - Ажил гүйцэтгэхэд ашиглахаар заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл, (өөрийн өмчлөл, эзэмшилийн, түрээслэх гэх мэт); - Техникийн чадавх болон туршлагын талаар заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж буйг нотлоход шаардлагатай бусад баримт. 				
ТШЗ 19.3	Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “Шаардана.” “Бага төвөгшилтэй барилга байгууламжийн угсралт, өргөтгөл, шинэчлэлтийн ажил				

	<ol style="list-style-type: none"> 1. “Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсаралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохиижилтын ажил” БА-2.1 ба түүнээс дээш 2. “Барилга байгууламжийн дотор ус хангамж, ариутгах татуургын сүлжээ, тэдгээрийн тоног тохөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт” БА-6.1 3. “Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, хөргөх байгууламж тэдгээрийн тоног тохөөрөмж, гадна шугам сүлжээний угсралт” БА 6.2. 4. “Барилга байгууламжийн дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тэдгээрийн тоног тохөөрөмж, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт” БА-6.3 5. “Барилга байгууламжийн дотор холбоо дохиолол, интернет сүлжээ, гал унтраах болон галын аюулын дохиоллын системийн угсралт, тэдгээрийн тоног тохөөрөмж, тухайн барилгын гадна шугам сүлжээний угсралт” БА-6.4.
ТШЗ 21.6	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 24.1	Тендерийн баталгааны дүн: Төсөөт өртгийн 0.5% буюу 14,000,000.00 /арван дөрвөн сая/ төгрөг

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /цахим/ 2. Тендерт оролцогчийг төлөөлөх эрх бүхий этгээдийн итгэмжлэл 3. Тусгай зөвшөөрөл: Шаардана./ ТШББ-ийн ΘХ-ийн ТШЗ-19.3-т заасан/ 4. НӨАТ төлөгчийн гэрчилгээ 5. Шүүхийн тодорхойлолт /цахим/ 6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт/цахим/ 7. Санхүүгийн тайлангийн мэдээлэл /цахим/ 8. Татвар төлөлтийн тодорхойлолт /цахим/ 9. Ажлыг гүйцэтгэхээр тооцоолсон төсөв, түүний задаргааг Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох программаар гүйцэтгэж, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулан ирүүлнэ. 10. Харилцагч банк, татварын алба, нийгмийн даатгалын байгууллагаас лавлагаа авахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдэл <p>Жич: Оролцогч, түншлэгч нь тендер шалгаруулалт зарласнаас хойш хугацаанд цахим системтэй холбогдсон мэдээллийн сангаас “цахим” гэж заагдсан мэдээллүүдийг цахим системээр дамжуулан татан авч, тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө уг цахим системийн холбогдох хэсэгт зааварчилгааны дагуу холбон баталгаажуулж илгээнэ.</p> <p>Бүдэг харагдахгүй болон ойлгомжгүй ирүүлсэн тохиолдолд тус тендерийн материалыг хүчингүйд тооцно.</p> <p>Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулсан байна. Нууцалсан баримт бичиг,</p>
----------	---

	мэдээллийн жагсаалтыг Маят 7-ын дагуу ирүүлнэ. Маят-7-д ороогүй бусад файл, мэдээллийг цахим системд “Нууцлахгүй” төлөвтэйгээр илгээнэ.
ТШЗ 26.1	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 5 дугаар сарын 24 өдөр Цаг: 10 цаг 00 минут
ТШЗ 26.2	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөр Цаг: 10 цаг 05 минут Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, “Монголросцветмет” ТӨҮГ

Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ

ТШЗ 31.1	Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: Шаардахгүй.
ТШЗ 32.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

ТШЗ 37.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Тийм” <i>Тендерт шалгарч, гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд нийт төсөөвт өртгийн 3 хувиар тооцож, хуулийн 42.3-т заасан хэлбэрээр гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.</i>
-----------------	---

Ё. БУСАД

ТШЗ 38.1	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”
-----------------	---

I БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Тендерийн нэр: 36 айлын орон сууц
Тендерийн дугаар: МРЦМ/20240101087

Хэнтий аймгийн Бор-Өндөр сум 2-р багийн нутаг дэсвэгэрт баригдах 36 айлын орон сууцны барилга (түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй барих) АЖЛЫН ДААЛГАВАР

1. Зураг төсөл боловсруулах, дахин төлөвлөлтийн барилга угсралтын ажил гүйцэтгэх үндэслэл	<ul style="list-style-type: none">- Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль- Монгол улсын Барилгын норм ба дүрэм- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм /ЗГ-ын 2019 оны 108-р тогтоолоор батлагдсан/- Хэнтий аймгийн ерөнхий архитекторын баталсан 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан “Архитектур төлөвлөлтийн даалгавар”, №АТД-23-013/23- БХБЯ БХТ-ийн 2023 оны 08-р сарын 03-ны өдрийн №1180/2023 ББЗТ-ийн магадлалын дүгнэлтийн нэгтгэл- Хэнтий аймгийн ЭМГ-ын Улсын байцаагчийн дүгнэлт, 2023оны 05 дугаар сарын 22-ны өдрийн №10-34-02/128/15- ОБЕГ-ийн гол түймрийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн №61/15- “Монголросцветмет” ТӨҮГ-ын 2024 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
2. Байршил	Хэнтий аймаг, Бор-Өндөр сум 2-р баг Их тойруу-3 гудамж “Монголросцветмет” ТӨҮГ-ын харьяа Бор-Өндөр УБҮ-ийн эзэмшил газарт
3. Барилга байгууламжийн нэр, зориулалт	Захиалагч: “Монголросцветмет” ТӨҮГ 4 ба түүнээс доош давхрын нийтийн орон сууцны барилга
4. Хүчин чадал, барилгын давхар, талбайн зохион байгуулалт, өрөөний хэмжээ	<ol style="list-style-type: none">1. Барилгажих талбайн хамгийн их хэмжээ 756 м2. Энэхүү батлагдсан талбайн хэмжээнд багтаан төлөвлөнө.2. Давхрын тоо: Угсармал хавтгайлжин бүтэцтэй (зоорийн давхрын хамт) ± 0.00 түвшнээс доош 1 давхар ± 0.00 түвшнээс дээш 3 давхар байна.3. Өрөөний хэмжээ, орон сууцны тоо барилгад нийтдээ 1-3 өрөөтэй, нийт 36 айлын орон сууц төлөвлөнө. <p>Тайлбар: (Ажлын даалгаврын хавсралт хэсэг дэх барилгын эскиз, давхрын байгуулалтын загвар зураг, тооцооллоос барилгын талбайн болон өрөөний тоо, хэмжээг дэлгэрүүлж үзнэ үү)</p>
5. Талбайн өрөнхий төлөвлөгөө, ногоон байгууламж, барилга байгууламж, авто зогсоол, амрах тоглоомын талбай, гадна тохижилт,	<ul style="list-style-type: none">- Хот байгуулалтын тухай хууль, Барилгын тухай хууль- Монгол улсын Барилгын норм ба дүрэм- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм /ЗГ-ын 2019 оны 108-р тогтоолоор батлагдсан/- “Архитектур төлөвлөлтийн даалгавар”, №АТД-23-013/23-д заасныг баримтална.- Монгол улсын холбогдох стандартууд (MNS 52719:20148, MNS 6489:2014, MNS 6491:2014, MNS 6490:2014 стандарт)

<p>инженерийн байгууламжид тавих үндсэн шаардлага</p>	<p><u>Барилга угсралтын ажлын зохион байгуулалт, хөдөлмөр хамгааллын ажилд:</u> БНБД 12-01-09, БНБД 12-03-04, БНБД 12-04-06, БД 12-101-05 ийг тус тус баримтлан ажиллана.</p> <p><u>Төмөр бетон ба бетон бүтээцийн ажилд:</u> БНБД 52-01-10, БНБД 52-02-05, БНБД 52-03-05 болон бусад холбогдох норм дүрэм, бүтээцэд орох материалд хүчин төгөлдөр үйлчилж байгаа улсын стандартыг мөрдлөгө болгоно. Лабораторийн шинжилгээтэй, стандарт хангасан, гэрчилгээтэй цемент, арматур, элс, хайрга, дайргыг хэрэглэнэ.</p> <p><u>Барилгын суурьт</u> хэрэглэх материал эдлэхүүн, хийц бүтээц нь стандарт, техникийн нөхцөл, шаардлагыг бурэн хангасан байна. БНБД 3.02.01-90, БНБД 3.03.05-90, БНБД 3.03.02-90, БНБД 3.03.01-88, БНБД 3.04.01-88 ыг мөрдлөг болгоно.</p> <p><u>Хаалга, модон бүтээцийн ажлыг</u> БНБД 54-02-05-ын дагуу гүйцэтгэх ба модон эдлэхүүн, материалд улсын стандарт MNS 394-5488, MNS 2381-94 ийг мөрдөнө.</p> <p><u>Цонхыг</u> эрх бүхий байгууллагад захиалж, З давхар шил бүхий вакуум цонх хийнэ. Чанарын сертификат, баримттай байна.</p> <p><u>Хана хамар ханын өрөг бүтээц:</u> БНБД 2.03.02-09, БНБД 51-02-05 ийг мөрдлөг болгох ба бат бөх, гадна дотор дуу чимээг тусгаарласан байна.</p> <p><u>Барилгын дуу, дулаан тусгаарлалтын ажилд</u> БНБД 31-08-05 ийг мөрдөн ажиллах ба дуу дулаан тусгаарлах материал, эдлэхүүн, эдлэлүүд нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа улсын стандарт, техникийн баримт бичгийн шаардлага хангасан байна. Хөөсөн полистрол нь MNS 4629-98 стандартын шаардлага хангасан байна.</p> <p><u>Ус тусгаарлалтын ажил:</u> Дэзврийн ажлыг БНБД 31-07-05 ийн дагуу гүйцэтгэх ба тусгаарлалт, хамгаалалтын бүрээсийн ажил зураг төслийн дагуу хигдсэн байна. Дээвэр, уур, ус тусгаарлалтад хэрэглэх материал эдлэхүүн нь стандартын шаардлага хангасан байна.</p> <p><u>Шалны ажилд</u> БНБД 31-12-08, БНБД 31-09-05, БНБД 54-02-05 ийг мөрдлөг болгон гүйцэтгэх ба батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p><u>Заслалын ажил:</u> Барилгын гадна, дотор заслалын ажилд БНБД 31-10-05 ийг мөрдлөг болгон ажиллах ба заслын ажлыг нэмэх температуртай орчинд хийнэ. Заслын ажилд хэрэглэгдэх материалууд хүчин төгөлдөр үйлчилж байгаа стандарт, техникийн баримт бичгийн шаардлага хангасан байна. Будаг, шингэлэгч зэрэг үнэрт материалууд нь харшил үүсгэхүй чанарын баталгаа, гарал үүслийн гэрчилгээ, сертификаттай байна.</p> <p><u>Цахилгаан сантехникийн ажил:</u> Гадна дотор цахилгаан, сантехникийн ажилд БНБД 3.05.06-9, БНБД 3.01.01-90, БНБД 3.01.05-90 ийг мөрдлөг болгох ба халаалт, халуун, хүйтэн ус, бохир ус, салхивч, ариутгах татуургын ажлыг БНБД 3.05.01-88, БНБД 50-05-98, батлагдсан зураг төсөл, техникийн нөхцөлийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p><u>Гадна тохижилтын ажил:</u> Барилгын орчны тохижилтын ажилд</p>
---	---

	БНБД 3.01.06-90, батлагдсан зураг төсвийг мөрдлөг болгон ажиллана. Тохижилтын ажилд хэрэглэгдэх материалууд нь зохих стандарт болон техникийн шаардлагыг хангасан байна.
5. Захиалагчаас тавих шаардлага:	<p>1. Захиалагч нь барилга барих газрын зөвшөөрөлтэй холбоотой баримт бичиг батлагдсан зураг төсөв, техникийн нөхцлийг бүрдүүлэн гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө.</p> <p>2. Шалгарсан оролцогч нь /ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10-т заасны дагуу/ батлагдсан зураг төсөв, 2023 оны 08-р сарын 03-ний өдрийн 1180/2023 барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлт, техникийн нөхцөл тэдгээрт заасны дагуу түлхүүр гардуулах гэрээний нөхцлөөр, гадна дэд бүтэц, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх, эдгээр ажилд шаардлагатай болон барилгын ажилд шаардлагатай техник тоног төхөөрөөмж, материал, түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх, барилга угсралтын ажлыг гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэн өгч дуусган, захиалагчийн өмчлөл, ашиглалтад шилжүүлэн өгөх ажлыг хийж гүйцэтгэнэ:</p> <ul style="list-style-type: none"> a) Дахин төлөвлөлт, барилга барихтай холбоотой инженер геологийн судалгаа, иж бүрэн зураг төсөл , магадлалаар батлуулсан зураг төсөл, ажлын зураг, төсвийн дагуу хийж гүйцэтгэх b) Холбогдох байгууллагуудаас баталгаажуулсан техникийн нөхцлүүд, тэдгээрт заасан нөхцөлийн дагуу хийж гүйцэтгэх, c) Барилгын инженерийн гадна дэд бүтцийг хийж гүйцэтгэх d) Барилга угсралтын ажлыг батлагдсан зураг төсөв, барилгын норм ба дүрэм, стандартын дагуу гүйцэтгэж, улсын комисст иж бүрэн хүлээлгэн өгөх, <p>1. Барилгын чанарт 3 жилээс доошгүй хугацаатай баталгаа гаргах,</p> <p>2. Барилгын талбай дахь холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, дэг журам, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, харуул хамгаалалтын үйл ажиллагааг бүрэн хариуцна.</p> <p>3. Барилга нь угсармал төмөр бетон бүтээц хийцтэй байх бөгөөд бүтээцүүд болон дүүргэгч материалууд нь орчны нөлөөлөл, сөрөг хүчин зүйлийн болзошгүй нөлөөллийг тэсвэрлэх материалаар хийгдсэн байх.</p> <p>4. Барилгад холбогдох норм стандартын шаардлага хангасан, Олон улсад болон Монгол улсад ашиглахыг хүлээн зөвшөөрсөн, бат бөх, орчин үеийн хийц загвартай тоног төхөөрөөмж, түүхий эд, материалыг ашиглана.</p> <p>5. Гүйцэтгэгч нь барилгад ашиглах тоног төхөөрөөмж, материал, түүхий эдийн танилцуулга, гарал үүсэл, стандартын гэрчилгээ, биет загварыг захиалагч, зураг</p>

	<p>төслийн зохиогчид танилцуулан, зөвшилцөж, зөвшөөрөл авсны дараа худалдан авч, ашиглана.</p> <p>6. Барилгын гадна фасад нь ISO стандартыг хангасан галд тэсвэртэй, өнгө үзэмжтэй хийцлэлтэй байна.</p> <p>7. Барилга нь инженерийн шугам сүлжээний төвлөрсөн ба бие даасан шийдэлтэй байх. Үүнд: усан хангамж, ариутгах татуурга, халаалт, агаар сэлгэлт, галын систем, цахилгаан, интернэт, телефон, телевизийн сүлжээ, кабелиудттай, хог зайлуулах цэгтэй байх.</p> <p>8. Барилгын хийц бүтээцийн гадаргууд ил буюу далд угсрах цахилгааны шугам нь шаталт тархдаггүй бүрээстэй, ашиглалт болон стандартын шаардлага хангасан кабель болон тусгаарлалттай утсаар хийгдсэн байх.</p> <p>9. Барилга байгууламж нь галын аюулаас хамгаалах нэгдсэн галын дохиолол мөн давхар бүрд гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр бүрэн хангагдсан байх.</p> <p>10. Хүн оршин суух таатай нөхцлийг бүрдүүлсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан байх, дуу чимээнээс хамгаалагдсан байх.</p> <p>11. Хамгаалалтын хяналтын камерыг барилгын гадна талбай болон дотор орц, давхар бүрд мөн автозогсоолд суурилуулсан байх.</p>
--	---

ЗУРАГ

САНАМЖ

Хэнтий аймгийн Ерөнхий архитектораар баталгаажуулсан “Загвар зураг” болон “Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК-ний хийж гүйцэтгэсэн “Ажлын зураг”-ийг үндэслэнэ.

Ажлын даалгаврын хавсралт

1. Байршлын зураг: Хэнтий аймаг Бор-Өндөр сум, 2-р баг
2. Хэнтий аймгийн Ерөнхий архитекторын батласан Загвар зураг
3. “Хот төлөвлөлтийн хүрээлэн” ХХК-ийн гүйцэтгэсэн ажлын зураг,
4. 36 айлын угсармал орон сууцны барилгын ажлын төсөв.
5. Хэнтий аймгийн ЭМГ-ын Улсын байцаагчийн дүгнэлт /2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн №10-34-02/128/15/
6. Монгол улсын Засгийн газрын тохируулагч агентлаг ОБЕГ-ийн гал түймрийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт /2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн №61/15/
7. Хэнтий аймгийн ерөнхий архитекторын 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр баталсан “Архитектур төлөвлөлтийн даалгавар” / № АТД-23-013/23/
8. “Инженер геодези” ХХК-ний хийж гүйцэтгэсэн Инженер-геологийн судалгааны тайлан
9. ШУТИС БАС Барилга экспертизийн тайлан
10. Барилгын эрчим хүчний гэрчилгээ №БХТ-ЗТ-0381/2023

11. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Засаг даргын захирамж № А/06
12. Ус, дулаан хангамж, ариутгах татуурга, түүний техникийн нөхцөл №22/06
13. Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл №01/23
14. Мэдээлэл холбооны сүлжээний техникийн нөхцөл А-1
15. Техникийн нөхцөл- дулаан хангамж №23/01
16. Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлт 1180/2023

Шалгалт, туршилт

Захиалагч Тендерт оролцогчоос тендерт заагдсан барилгын бэлтгэл ажил, суурийн ажил, угсралт монтажийн ажлын үе шатны хуваарийг ирүүлэхийг шаардана.

Үе шатны ажлын хуваарь

Ажлын гүйцэтгэлийг хянаж шалгахад үе шатны ажлын хуваарийг ашиглана.

1. Барилга угсралтын ажлыг эхлүүлэх хугацаа:

Гэрээ байгуулснаас хойш ажлын 7 хоногийн дотор

2. Барилгын ажлыг дуусгах /ашиглалтад хүлээлгэн өгөх/хугацаа:

Гэрээ байгуулснаас хойш 15 сарын дотор

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Ажил дуусгах хугацаа: “*Ашиглахгүй*”

Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарыт зааснаас [тоо бичих]-аас илүү [“сар”, “өдөр” гэдэг үнээс сонгож бичих] хоироож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.

1. Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: “*Ашиглахгүй*”
2. Байгаль орчинд нөлөөлөх байдал: “*Ашиглахгүй*”
3. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: “*Ашиглахгүй*”

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягт 1. Тендер илгээх

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Маягт 1. Тендер илгээх

[огноо]

“Монголпросцветмет” ТӨҮГ-т

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [30 ба түүнээс дээш хоногийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,

албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	/“Өөрийн эзэмшил” эсхүл “турээс” аль нэгийг бичих/

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		
4.		
5.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:

- 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
- 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
- 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
- 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамгад нь нэрлэснийг;
- 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
- 1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
- 1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
- 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
- 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
- 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

- Тайлбар
- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
 - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.
 - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
 - 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
 - 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
 - 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

- Захиалагчийн нийтлэг үүрэг
- 2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.
 - 2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.
 - 2.3. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.
- Захиалагчийн төлөөлөгч
- 2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.
 - 2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
 - 2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Талбайд нэвтрэх зөвшөөрөл
- 2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.
 - 2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- | | |
|---------------------------------------|---|
| Гүйцэтгэгчийн нийтлэг үүрэг | 3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.
3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.
3.3. Ажил гүйцэтгэхэд шаардлагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.
3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.
3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.
3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана. |
| Гүйцэтгэгчийн төлөөлөгч | 3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.
3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно. |
| Техникийн болон ажлын талбайн өгөгдөл | 3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогоеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө. |
| Ажлын талбайн харуул хамгаалалт | 3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.
3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна. |
| Хог, хаягдал ба нөхөн сэргээлт | 3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.
3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана. |

- Археологийн болон бусад олдвор
- Аюулгүй байдал
- Ажил эхлэх
- Хугацаа сунгах
- 3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.
 - 3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.
 - 3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.
 - 3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
 - 3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
 - 3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
 - 3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
 - 3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
 - 3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
 - 3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

- Ажил эхлэх
- Хугацаа сунгах
- 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
 - 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
 - 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
 - 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.
 - 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
 - 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй

	<p>хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;</p> <p>4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;</p> <p>4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;</p> <p>4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.</p>
Ажлын явцын тайлан	<p>4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.</p> <p>4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.</p> <p>4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.</p> <p>4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.</p> <p>4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.</p>
	<p>ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ</p>
Гэрээний үнэ	<p>5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.</p> <p>5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.</p>
Урьдчилгаа төлбөр	<p>5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.</p>
Төлбөрийн нөхцөл	<p>5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.</p> <p>5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.</p> <p>5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг</p>

төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.

- 5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
- 5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
- 5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

Урьдчилгаа баталгаа	төлбөрийн	6.1. ГЕН-ийн 5.4-т заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ.
Гүйцэтгэлийн баталгаа	6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.	
	6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангулна: <ol style="list-style-type: none">6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.	
	6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.	
	6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.	
	6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.	

- | | |
|---|---|
| <p>Чанарын баталгаа</p> <p>Баталгаат хугацаа</p> <p>Бусдад учруулсан хохирлыг арилгах</p> <p>Захиалагчийн хүлээх эрсдэл</p> | <p>6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.</p> <p>6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>6.9. ГЕН-ийн 6.7-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.</p> <p>6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> <p>6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.</p> <p>6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.</p> |
| <p>ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ</p> | |
| <p>Захиалагчийн хүлээх эрсдэл</p> | <p>7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.</p> <p>7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <ul style="list-style-type: none"> 7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан; 7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан; 7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан; 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл. <p>7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх</p> |

хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.

Даатгал

- 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

Доголдлыг арилгах

- 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
- 8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг ирүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
- 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.
- 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.

- Далд доголдол
- Зураг төслийн доголдол
- Захиалагч гэрээг цуцлах
- Гүйцэтгэгч гэрээг цуцлах
- 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.
- 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.
- ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ**
- 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;
- 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гаралаагүй;
- 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;
- 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
- 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
- 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
- 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
- 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
- 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;

- Гэрээг цуцлах журам
- 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх өрдийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгэгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дунд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэг ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэнээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр
- 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
 - 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
 - 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
 - 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
 - 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

- Мэдэгдэл
- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт,

нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.

10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.

10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.

10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.

10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.

Төлөөлөгч өөрчлөгдөх

10.12. Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын өрөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.

10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.

10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.

10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.

Ажилд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл

- Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал
- 10.16. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
- 10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.
- Оюуны өмчийн эрх зөрчих
- 10.20. Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Алданги
- 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
- 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцэх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцэж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- Маргаан шийдвэрлэх

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	Ажил эхлэх хугацаа: <i>Гэрээнд заасны дагуу</i>
ГЕН 4.2.	Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: <i>Гэрээ байгуулагсанаас хойши ажлын 5 хоногт</i>
ГЕН 4.9.	Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: <i>Тайланг гэрээт ажлын хуваарьт заасан хугацаанаас хойши ажлын 5 хоногт багтаан</i>
ГЕН 5.2.	Үнийн тохируулга: “Хийхгүй”
ГЕН 5.4.	Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй” Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: 0
ГЕН 5.5.	Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: <i>Урьдчилгаа төлбөр олгохгүй</i>
ГЕН 5.6.	Төлбөр төлөх хугацаа: Техникийн тодорхойлолтод заагдсан ажил гүйцэтгэх хуваарийн дагуу хийгдсэн ажлын төлбөрийг гүйцэтгэлээр төлнө. Үүнд: 1-р шат: Барилгын гүйцэтгэлийн 40% дууссаны дараа: Гэрээний үнийн дүнгийн 30%, 2-р шат: Барилгын гүйцэтгэлийн 60% дууссаны дараа: Гэрээний үнийн дүнгийн 25 %, 3-р шат: Барилгын гүйцэтгэлийн 80% дууссаны дараа: Гэрээний үнийн дүнгийн 20 %, 4-р шат: Барилгын гүйцэтгэл 100% буюу улсын комисст хүлээлгэж өгсөний дараа гэрээний үнийн дүнгийн 20%-ийг тус тус төлнө. Ажлыг захиалагчид хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 60 хоногийн дотор холбогдох ажлын гүйцэтгэлийн акт, нэхэмжлэхийг үндэслэн дээр дурдсан хуваарийн дагуу төлнө. Чанарын баталгааны хэмжээ болох гэрээний үнийн дүнгийн 5%-ийг барилгын чанарын баталгааны хугацаа дуусмагц төлнө.
ГЕН 6.1.	Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: 0 Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: <i>ашиглахгүй</i>
ГЕН 6.7.	Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: “Шаардана.” Чанарын баталгааны хэмжээ: <i>Гэрээний үнийн дүнгийн 5 хувь</i>
ГЕН 6.13.	Баталгаат хугацаа: <i>Ажил дууссанаас хойши 36 сар</i>
ГЕН 7.5.	Даатгал: <i>Гүйцэтгэгч гэрээт ажлыг гүйцэтгэн ажиллах ажилтнуудын гэрээ хэрэгжүүлэх хугацаанд эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгал болон ажлыг гүйцэтгэхэд ашиглах тээвэр, үйлчилгээ болон машин техник, тусгай хэрэгслийг зохих журамын дагуу бүрэн даатгуулна.</i>
ГЕН 10.21.	Захиалагчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: Хоног тутамд 0.01 хувиар тогтоох ба нийт дүн нь гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна.
ГЕН 10.22.	Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Алдангийн хувь: Хоног тутамд 0.01 хувиар тогтоох ба нийт дүн нь гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ
“36 айлын орон сууц” барих ажлын гэрээ.

Дугаар № МРЦМ/20240101087

..... хот/аймаг

Нэг талаас “**Монголпросцивемет** ТӨҮГ” (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
- 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
- 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
- 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
- 3.7. Техникийн тодорхойлолт;
- 3.8. Ажил гүйцэтгэх хуваарь.

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:

- 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

- 4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА